

ИРГЭНИЙ НИЙГМИЙГ ЯАГААД ХАМГААЛАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?



Иргэний нийгэм бол чөлөөт ардчилал, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын биелэл төдийгүй боломж, алсын өргөн хараагаа хэрэгжүүлэх нэгэн талбар болж байдаг. Учир нь иргэний нийгэм оршин тогтносноор хүмүүс эвлэлдэн нэгдэж, үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлж, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан аливаа алхмуудын эсрэг зогсох хүчтэй, сэдэлтэй болж чаддаг.

Иргэний нийгэм нь хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хүмүүнлэг, алагчлалгүй байдлыг үнэт зүйлээ болгон түүний салшгүй, харилцан хамааралтай, хуваагдашгүй байх чиг шугамыг баримталж ажилладаг. Ингэхдээ иргэний нийгэм аливаа үйл ажиллагаандаа дараах үүргийг хэрэгжүүлдэг билээ.

Нийгмийн сайн сайхны төлөө иргэдэд нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээнд анхаарлаа хандуулдаг.

Сайн нийгэм, засаглал хэрэгжих гол шалгуур бол иргэд эрх чөлөөтэй, боловсролтой, сонголт өргөн байх явдал байдаг. Иймд иргэний нийгэм иргэдийн боловсрол, эрүүл мэнд гэх зэрэг суурь олон хэрэгцээ зэрхэн хангагдсан байх зэрэгт анхаарч ажилладаг.

Эрх ашиг нь хөндөгдөж байгаа нийгмийн янз бүрийн бүлэгт хүрч бас тэдний дуу хоолойг нь илэрхийлдэг.

Аливаа бодлого, үйл ажиллагаа хэрэгжих явцад байгаль орчин, нийгмийн цөөнх, эмзэг бүлэг гэх мэт чухал талбарууд эрх баригчдын анхаарлаас гадуур үлдэх, хохирох үзэгдэл заримдаа гарах эрсдэлтэй. Ийм үед иргэд ганц нэгээрээ үзэл санаагаа илэрхийлж, дуу хоолойгоо өргөж тэмцэж чадахгүй байх бэрхшээл бий. Харин зорилго чиглэл нь тодорхой болсон иргэний нийгмийн байгууллагууд иргэдийг нэгтгэх, төлөөлөх, өмгөөлөх, төрд болон олон нийтэд тэдний асуудлыг хүргэх янз бүрийн кампанит ажлуудыг санаачлан хэрэгжүүлдэг юм. Иргэний нийгэм засгийн газар, бизнесийнхэнд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, уриалах зэргээр хувь хүн, бүлгүүдийг дэмждэг, холбодог билээ.

Төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаа зүй зохистой эсэхэд хяналт тавьдаг.


Иргэний нийгмийн чухал нэг үүрэг бол засгийн газар, эрх баригчдын үйл ажиллагаагаа шударга, нээлттэй буюу олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүдтэй нийцэж ажиллаж буйд хяналтаа тавьдаг. Ардчилсан улсын хувьд ард түмнээс сонгогдсон эрх мэдэл бүхий албан тушаалтан, татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг төрийн байгууллага хариуцлагатай, ил тод байх ёстой бөгөөд энэ замаар иргэний нийгэм ардчиллыг бэхжүүлдэг.

Иргэдийн үзэл санааны биелэл болох эрхэм зорилгын үүднээс засаглалын үйл явцад оролцдог.

Иргэний нийгмийн байгууллага нь төр, хувийн хэвшлийн үйл хэрэгт, нийгмийн бүлгүүдийнхээ хэрэгцээ шаардлагыг төрийн бодлого, үйл ажиллагаанд тусгуулах, зөвлөх замаар засаглалын үйл явцад оролцдог. Бас үйл ажиллагаа нь өргөн хүрээ бүхий олон улсын байгууллагуудын бодлогод ч бас зөвлөж, нөлөөлж чадах байр суурийг тээж чадна. Шийдвэр гаргах түвшинд иргэний нийгэм хүчтэй дуу хоолой болж чаддаг байх нь нийгмийн ялгаатай бүлгүүдэд учирдаг сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх зэрэг үр нөлөө ихтэй байх билээ.

Иргэдийн идэвхтэй оролцоог бий болгож, сэдэлжүүлж, чиглүүлдэг.

Иргэний нийгэм энгийн иргэдийг чадавхижуулж, сэдэлжүүлж, бас оролцуулж байдгаараа өөрийн "иргэний" гэсэн утгаа тодотгож баталж байдаг. Иймд өөрсөдтэй нь холбоотой шийдвэр гаргах ямарваа асуудалд иргэдийн анхаарлыг хандуулж, тэднийг орон нутгийн, бүсийн, үндэсний түвшинд байр сууриа илэрхийлж идэвхтэй ажиллахад иргэний нийгэм тэгш оролцоог дэмжиж, хангаж ажиллахыг эрмэлздэг юм.



Иргэний нийгмийн байгууллагууд, идэвхтнүүдийн олон улсын нийгэмлэг CIVICUS байгууллагаас жил бүр иргэний нийгмийн нөхцөл байдлын талаарх тайлан гаргадаг. 2019 оны 153 орныг хамруулсан тайланд дурдсанаар өдгөө дэлхийн хүн амын ердөө 3% нь нээлттэй, 27% нь хаалттай иргэний нийгмийн орчинд амьдарч байгаа ажээ. Монгол Улс иргэний нийгмийн хөгжлийн хувьд дутагдалтай, дундаж гэсэн үзүүлэлттэй байгаагаас харахад ардчиллыг бэхжүүлэх, иргэний нийгмийг чадавхижуулах, дэмжих талаар анхаарах хэрэгтэй нь харагдаж байна.

Иргэний нийгмийн орон зай хумигдмал байхын хэрээр эрх баригчдын бодлого, шийдвэр нийгэмд хүртээмжтэй байх байдал саарч улмаар иргэдийн дуу хоолой хязгаарлагдан өөрсдийнхөө сайн сайхны төлөө тэмцэх боломж саарах билээ. Энэ бол иргэдийн суурь эрх болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн эсрэг байдал буюу ардчилал өөрөө бүүдийх эхлэл юм.

Иргэний нийгмийг яагаад хамгаалах хэрэгтэй вэ?

Иргэний нийгэм нь нийгмийн бүлгүүдийнхээ хөндөгдөж буй эрх ашгийн төлөө ажилладаг, нийгмийн баримжаа өргөн байдгийн хувьд олон үйл ажиллагаа зохион байгуулж, иргэдийг идэвхжүүлэн, хамтын оролцоотойгоор хөгжих үзэл санааг түгээн дэлгэрүүлдгийн жишээг **гурван талбараар** тодотгоё.

Иргэний нийгмийн нийгэмд гүйцэтгэдэг үүрэг

Зорилгот бүлгийг дэмжих тухайд

Нийгмийн тодорхой бүлгүүдийн эрх ашгийг төлөөлөн дуугарч, иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэн жагсаал, хөдөлгөөнүүдийг иргэний нийгмийн байгууллагууд зохион байгуулдаг. Энэ нь ч иргэдийг сэдэлжүүлж, оролцоог хангах нэг арга зам байдаг. Тухайлбал Монгол улсад хүүхэд хамгааллын бодлогод нухацтай хандахыг сануулсан таагүй мэдээллүүд олонтаа гарах болсон бөгөөд хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээний нээлттэй байдлын үрээр иргэдийн сонор улам мэдрэг байгаа юм. Хөдөлмөрийн аюулгүй байдал, орон гэрт болон хаа сайгүй хүүхэд ээлтэй орчин хангалтгүй байгааг, мөн гэр бүлд хандах нийгмийн ухаалаг бодлогыг шаардсан хүүхдийн хүчирхийллийн эсрэг "Дахин тэвчихгүй" тайван жагсаалыг олон нийтээрээ зохион байгуулсан нь тод жишээ байлаа. Жагсаалыг дэмжин 400 гаруй мянган гишүүд цахимаар нэгдэж, Улаанбаатар хот, 14 аймаг, 8 улс орноос Монголчууд нэгдэн, эсэргүүцлээ илэрхийлж байв. Уг жагсаалд 100 гаруй мянган иргэд биеэр оролцон Сүхбаатарын талбайд жагссан юм. Энэ мэт эсэргүүцлийн жагсаалын үрээр хүүхдийн эсрэг хүчирхийлэл, нийгмийн хяналт, хүүхэд хамгааллын асуудал бодлогын түвшинд анхааралд орсон байна. Мөн 7 ээж нэгдэж утааны эсрэг тэмцэж, улмаар Утааны эсрэг ээж аавуудын холбоо байгуулагдан 2017 онд 10 мянга гаруй иргэд оролцсон жагсаал болон хувирч засгийн газрыг утааг бууруулах чиглэлд дорвитой ажил хийхгүй байгааг шүүмжилсэн жишээ бий. Уг хөдөлгөөнд 7000 гаруй иргэд гарын үсгээ зурсан бөгөөд утааны асуудал бол засгийн газар хэрхэн ажиллаж буйг харуулах нэг илтгэцүүр болсон юм.

Байгаль хамгаалах үйл ажиллагааны хувьд

Байгаль орчинд өөрчлөлт ороход иргэдийн амьдрал дагаж өөрчлөгддөг. Байгаль орчин сүйдэж эхлэхэд иргэдийн аж төрөлд сөрөг нөлөөлөл бий болж эхэлдгийг уул уурхайн жишээгээр илэрхийлж болно. Монгол улсын хувьд уул уурхайн олборлолт хийгдэж эхэлснээр орон нутгийн иргэдийн малын бэлчээр сүйдэж, ундны усгүйдэл, малын зүй бус хорогдлын талаар асуудлууд олноор гарах болсон. Иргэд уул уурхайн асуудал, нөхөн сэргээлттэй холбоотой төрийн бодлого, хариуцлага, үйлчилгээнд шүүмжлэлтэй хандах эхэлсэн юм. Зарим орон нутгийн иргэд гол горхины 11 албан бус нэгдлүүдийг нэгтгэж 2006 онд "Homeland and Water Protection Coalition of River Movements" хөдөлгөөнийг байгуулсан. Эдгээрээс Онги гол хөдөлгөөнийг онцолбол, 2006 оноос тус хөдөлгөөн гол мөрний урсалттай холбоотой маш олон нөлөөлөл, бодлогын ажил хийсний үр дүнд хоёр ч хуулийг хэлэлцэн батлуулжээ. "Гол мөрний урсалт бүрэлдэх усан сан бүхий газар хамгаалалтын бүс, ойн сав бүхий газар ашигт малтмалыг хайх, ашиглахыг хориглох тухай", "Байгаль орчны тухай" хуулиуд гарснаар төрийн бус байгууллага, иргэн шүүхэд байгаль орчинд учруулсан хохирол барагдуулах нэхэмжлэл гаргах эрхтэй болсон юм. Уг хөдөлгөөний үрээр Онги голын ойролцоох хайгуул хийх, уул уурхайн 37 лицензийн 36 нь цуцлагдаж орон нутгийн иргэд өөрсдийн эрх ашгийн төлөө үндэстэн дамнасан том корпораци, эрх мэдэлтнүүдийн эсрэг тэмцэж чадах олон улсын жишээ болж чадсан билээ.

Нийгмийн бүлгүүдэд анхаарал хандуулах тухайд

Ямарваа улс үндэстний орших тулгуур бол гэр бүл байдаг. Гэтэл эдийн засаг, нийгмийн шилжилтийн давлагаанд гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хамгийн их нэрвэгдсэн билээ. Энэхүү орхигдсон талбарт иргэний нийгмийн салбар ажиллаж "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай", "Хүүхэд хамгааллын тухай", "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай" хууль батлахад нөлөөлсөн юм. Эдгээр хуулиуд хүүхэд, залуучуудад чиглэсэн хамгаалал, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, тэднийг анхаарах эрх зүйн орчныг бүрдүүлснээрээ ихээхэн ач холбогдолтой. Мөн хохирогчийг яаралтай хамгаалах механизм бий болгож, энэ нь гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад дэм болсон юм. ҮСХ-ноос явуулсан "Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа - 2017" судалгаагаар Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртдөг бөгөөд 4 эмэгтэй тутмын 1 нь өөрийгөө хамгаалж хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв болон бусад төрийн байгууллагуудын олон жилийн нөлөөллийн үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна. Хүүхдийн хамгаалагдах эрхийг зохицуулсан эрх зүйн орчин бүрдэж, эмэгтэйчүүдийг хамгаалсан, залуучууд руу чиглэсэн үндэсний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгосон амжилт энд бий.